

Нотариатын ангийн үүсэл

БНМАУ-ын Засгийн газрын 1925 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн 38 дугаар хурлын 3 дугаар тогтоолоор Шүүх явдлын яамны "Гэрээ зэргийн гэрчлэн батлах хэргийг эрхлэх салаа" байгуулагдсанаар тус улсад Нотариатын байгууллагын үндэс тавигдсан.

Засгийн газрын 1931 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 7 хурлаас "Монгол Ард Улсын нотариатын дүрмийг баталсан нь нотариатын үйл ажиллагааны талаарх анхны эрх зүйн акт байв. Энэхүү дүрэм нь 16 бүлэгтэй, 38 зүйлтэй, гарчээ.

Нотариатын гэрчилгээ баталгаа хийсний үйлчилгээнд тэмдэгтийн хураамж авахдаа 1931 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн БНМАУ-ын Засгийн газрын эрхлэх товчооны 17-р хурлын 4 дүгээр зүйлээр батлагдсан "аливаа гэрээ, хэлэлцээний зэрэг зүйлээс хэрхэн хянаж татвар хураах тухай" дүрмийн баримталдаг байжээ.

Дүр-мэнд зааснаар шүүх явдлын яаманд гэрээ зэргийг гэрчлэх, нотариатын ажил эрхэлсэн түшмэл, аймгуудад аймгийн захиргааны ерөнхий хэлтэс, сумдад сумын захиргаа нотариатын үйл ажиллагаа эрхэлж байв.

1944, 1952, 1964 онуудад нотариатын дүрмийг шинэчлэн баталсан.

Шүүх яам татан буудсантай холбогдон Нотариатын байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үүргийг 1964 оноос Улсын дээд шүүхэд хариуцуулсан байна.

Монгол Улсад 1990 оноос эхэлсэн өөрчлөлт шинэчлэлийн хүрээнд 1992 онд батлагдсан шинэ үндсэн хуулийн дагуу хэрэгжүүлж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 1997 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн Монгол Улсын Нотариатын тухай хууль батлагдан гарснаар нотариатын байгууллагын тогтолцоо бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, үйл ажиллагааны хүрээ чиглэл үйлдлийн төрөл өргөжсөн,

Нийслэлийн Нотариатын газар нь Улаанбаатар хотын Улсын нотариатын контор нэртэйгээр Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 421-р тогтоолоор үүсгэн байгуулагдаж, үйлчилгээний орлогоосоо санхүүжигдэн Хууль зүйн яамны харьяанд ажиллаж байгаад Монгол Улсын тэмдэгтийн хураамж шинэчлэгдсэн болон Хотын нотариатын удирдлага зохион байгуулалт анд өөрчлөлт орсныг харгалзан Нийслэлийн Засаг даргын 1993 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/275 тоот захирамжаар 1994 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нийслэлийн Засаг даргын дэргэдэх нотариатын газар болж, төсөв дээр ажиллах болсон.

Тус газар нь Нийслэлийн харьяа Налайх, Багануур, Бага-хангай, Гачуурт, Жаргалант, Туул хороодод нотариатын үйл ажиллагааг хийж гүйцэтгэж, байгаа дотоод ажлын зохион байгуулагч нарын үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийх мэргэжлийн дагуу заавар зөвлөгөө өгөх аргачилсан удирдлагаар ханган ажиллаж байжээ.